



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 6/30

Улаанбаатар хот

С.Билгүүнд цалинтай чөлөө, буцалтгүй
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.19.2, 7.3.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус газрын Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн Авто үйлчилгээ хариуцсан ажилтан Сүхбатын Билгүүний эхнэр амаржиж, ам бүл нэмсэн тул 2020 оны 03 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд ажлын 5 өдрийн цалинтай чөлөө, нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгосугай.

2. Тэтгэмжийн зардал 50,000 төгрөг /тавин мянга/-ийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. С.Билгүүний албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн /Э.Нямсан/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР